

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн даргын 2018 оны 29 дүгээр сарын 26-ны өдрийн А/42 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

УХА0506 5611547

“ХЭРЭГЛЭГЧЭЭ СОНСЪЁ” НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсад Нийтийн аж ахуйн салбар үүсч хөгжсөний 87 жилийн ойг тохиолдуулан ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагааг хэрэглэгчдэд таниулах зорилгоор “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж, орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх гэж байна.

Энэхүү арга хэмжээг нийт тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд зохион байгуулж явуулах бөгөөд өдөрлөгийн үеэр иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын санал зөвлөгөөг сонсох, өргөдөл, гомдлыг хүлээн авч түүнийг шийдвэрлэх, зөвлөмж, зөвлөгөө өгөх, мэдлэг, мэдээлэл олгох, цаашид үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдийн тав тухтай амьдрах нөхцөл бололцоог хангахад чиглэсэн санал санаачлагыг хүлээн авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Аймаг, орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигчид уг арга хэмжээг тухайн аймгийн төвийн нийт хэрэглэгчдийн хүрээнд, УБ хотын тусгай зөвшөөрөл эзэмшигчид өөрсдийн хариуцаж буй орон сууцны хотхон, аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулан бие даан зохион байгуулна.

Хоёр. Хугацаа

Нийтийн аж ахуйн салбарын “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээ 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 10⁰⁰-16⁰⁰ цагийн хооронд орон даяар нэгдсэн журмаар зохион байгуулагдана.

Гурав. Хийж гүйцэтгэх ажил

Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд нь “Нээлттэй хаалганы өдөр”-өөр дээрх зорилгын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр уг арга хэмжээг зохион байгуулах талаар олон нийтэд зарлан мэдээлэх, сурталчлах;
- Байгууллагынхаа үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт болон тэдгээрийн эрх зүйн орчны талаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад нээлттэй, ил тод мэдээлэл өгөх;
- Ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр гаргасан төрийн байгууллагуудын бодлого, шийдвэрийг иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах;

- Ундны усны чанар, түүнд тавигддаг хяналтын талаар хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангах;
- Усны ухаалаг, зөв хэрэглээг олон нийтэд сурталчлах;
- Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэд, олон нийтэд мэдээлэл өгөх, түүнийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээний талаар хэрэглэгчдийн санал бодлыг сонсох;
- Усны үйлчилгээний үнэ тариф, үзүүлж буй үйлчилгээний чанар, төлбөр тооцоотой холбоотой хэрэглэгчдийн санал гомдлыг шуурхай хүлээн авч, шийдвэрлэх;
- Хэрэглэгчдийн ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний төлбөр тооцоог шуурхай барагдуулах, төлбөрийн урамшуулал, хөнгөлөлтийн талаар тодорхой ажлыг зохион байгуулах;
- Хэрэглэгчдээс ирүүлсэн санал, сэтгэгдлийг үндэслэн тэдгээрийн сэтгэл ханамжийн түвшинг бодитоор тодорхойлох;
- Хэрэглэгчдэд мэдээлэл өгөх, зөвлөмж хүргэх зэргээр үйл ажиллагаагаа сурталчлахдаа гарын авлага, материалуудыг бэлдэн тараах, хэвлэмэл болон цахим хэлбэрийг өргөнөөр ашиглах;

Дөрөв. Ажлын тайлан гаргах

Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд нийтийн аж ахуйн салбарын “Нээлттэй хаалганы өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлсэн ажлын тайланг гаргаж, Зохицуулах зөвлөлд 2018 оны 10 дугаар сарын 26-ны дотор ирүүлнэ.